



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.01.26 № 01/197  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД**

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан ЭТТХК/202301055/01/01 дугаартай “Тусгай тоноглолтой засварын техник” нийлүүлэх тендерийн Багц №2: “Тосолгооны зориулалтаар тоноглох автомашин”-тай холбогдуулж тодруулга хүссэн албан бичиг ирүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг үндэслэн 2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу хариу тодруулга, нэмэлт мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. 20 тн-ын 1 ширхэг контейнерыг тус тосолгооны зориулалтаар тоноглох автомашинд суурилуулна.

2. Тус автомашинд суурилагдах тосолгооны зориулалтаар тоноглогдсон контейнерын хэмжээ: Урт нь 6.20м, өндөр нь 2.70м, өргөн нь 2.55м хэмжээтэй нэг ширхэг контейнер суурилуулах боломжтой толгойтой (автомашин) байна.

3. Тодруулгад заасны дагуу тендерийн баримт бичгийн Багц №2: “Тосолгооны зориулалтаар тоноглох автомашин”-ны техникийн тодорхойлолтын 2-т өөрчлөлт оруулсныг үүгээр мэдэгдэж байна.

4. Тендерт оролцогч нь Багц №2 дахь техник нь дээрх тоноглогдсон контейнерын хэмжээнээс хамаарч аюулгүй байдал, тогтворжилт, савлагаа, чирэгч толгойн даац, үндсэн армын хэмжээ, урд болон хойд тэнхлэг хоорондын зай зэргийг бүрэн тодорхойлж шаардлагад нийцүүлсэн тохиромжтой (чирэгч толгой) автомашин байна.

Суурилуулах контейнерын зургийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 1 хуудастай.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ  
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ



Ж.ГАНБАТ

1124040367

**БАГЦ-2: ЧИГРЭГЧ ТОЛГОЙНД СУУРИЛУУЛАХ ТОНОГЛОГДСОН КОНТЕЙНЕРЫН ЗУРАГ**



**НЭМЭЛТ ТАЙЛБАР:**

- ❖ Тосолгооны зориулалтаар тоноглогдох автомашинд суурилуулах тоноглогдсон контейнерын бодит хэмжээс болон зураг болно.